

УРЬДЧИЛСАН ТАЙЛАН

2016 оны 5-р сарын 20-ноос 6-р сарын 14-ний өдөр

2016 оны 6-р сарын 17

I. ТОВЧ ХУРААНГУЙ

- 2016 оны 1-р сарын 21-ний өдөр парламент (*Улсын Их Хурал*)-аас ээлжит сонгуулийг 6-р сарын 29-ний өдөр явуулахаар товлов. Ээлжит сонгууль олонхийн буюу мажоритар тогтолцоогоор явагдах ба энэ нь санал өгөх өдрөөс хоёр сар орчмын өмнө хувь тэнцүүлсэн буюу пропорциональ тогтолцоог Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүчингүй болгож, УИХ сонгуулийн тогтолцоог түргэн өөрчилснөөс үүдэлтэй.
- Үндсэн хуулиар ардчилсан сонгуулийг бэхжүүлэх суурь эрх, эрх чөлөөг хангасан байдаг. Гэвч ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгуулийг ажиглах хороо (САХ)-ны гишүүдтэй уулзаж ярилцсан хүмүүс 2015 оны 12-р сарын 25-нд батлагдсан Сонгуулийн тухай хууль (СТХ) болон дараа нь оруулсан нэмэлт өөрчлөлтүүд дээр хуулийн хийдэл, хоорондоо зөрчилдсөн, тодорхой бус заалтууд хэд хэд байгааг тэмдэглэсэн юм.
- УИХ нэг мандат бүхий 76 сонгуулийн тойргийг 5-р сард байгуулж, тойргуудын нутаг дэвсгэрийн хил хязгаарыг батлав. Эдгээр тойрог нь засаг захиргааны нэгжтэй тэр бүр харгалзахгүй бөгөөд хүн амын тооноос нэлээд зөрж байна.
- Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) тэргүүтэй дөрвөн шатлал бүхий сонгуулийн байгууллага нь одоогийн байдлаар хуульд заасан чухал хугацаануудыг мөрдөн ажиллаж байна. Сонгуулийн байгууллагуудад ил тод байдал, шийдвэр гаргах албан ёсны нэгдсэн арга барил дутагдалтай, мөн олон нийтэд шаардлагатай мэдээ мэдээллийг цаг тухайд нь тэр бүр нийтлэхгүй байх явдал ажиглагдаж байна.
- Нийт 1,912,901 сонгогч 2016 оны сонгуульд оролцохоор бүртгэгдсэн. Гадаад улсад суугаа Монгол Улсын 150,000 орчим иргэн, мөн өөрсдийн оршин суугаа газрын сонгуулийн хэсгийн хороодоос өөр газар байршиж байгаа цэргийн албан хаагчид, цагдаа болон сонгуулийн байгууллагуудад ажиллаж буй ажилтнууд сонгуульд саналаа өгөх боломжгүй болж байна.
- УИХ-ын ээлжит сонгуульд нийт 498 нэр дэвшигчид өрсөлдөж байгаагийн 69 нь бие даагч байна. Нэр дэвшигчдээ бүртгүүлсэн 15 улс төрийн нам, эвслүүдээс зөвхөн Ардчилсан нам (АН) болон Монгол ардын нам (МАН)-аас нэг мандат бүхий 76 тойрогт бүгдэд нь өрсөлдөнө. Бүртгэгдсэн нэр дэвшигчдийн 26 хувь нь эмэгтэйчүүд байгаа хэдий ч эмэгтэй нэр дэвшигчгүй 27 тойрог байна.
- СТХ-иар сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгах зүйл зэргийг оролцуулан 6-р сарын 11-нээс эхлэн 17 хоногийн хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх эрх зүйн орчныг нарийвчлан

зааж өгчээ. Сонгуулийн зардлын тайланг сонгууль дууссаны дараа тайлагнахаас өөр шаардлагыг хуульд заагаагүй байна.

- Хэвлэл мэдээллийн салбар ил тод ажиллаж байгаа хэдий ч улс төрийн харьяаллаар тодорхойлогдож байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөл ил тод биш, улс төрийн намуудаас гаргаж буй төлбөртэй нэвтрүүлгүүд нь сонгуулийн сурталчилгааны өмнө редакцийн хараат бус байдлын агуулгыг сүүдэртүүлж байна. Олон нийтийн радио телевиз нь сонгуулийн сурталчилгааны үеэр төлбөргүй нэвтрүүлэх цагийг нэр дэвшигчдэд өдөрт долоо хүртэл цаг байхаар хуваарилна. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХ нь 5-р сарын 26-ны өдөр өөрийн хэвлэл мэдээллийн хяналт шинжилгээ (мониторинг)-г эхлүүлэв.
- Сонгуулийн тухай хууль нь сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг дээд шатны сонгуулийн байгууллагад гаргах ба СЕХ-ны шийдвэртэй холбоотой маргааныг Дээд шүүх хүртэл давж заалдах боломжтойгоор хуульчилсан. СЕХ дээр ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх үйл явцыг албан ёсны болгоогүй байна. Өргөдөл гомдлын тоо, агуулгын талаар олон нийтэд мэдээлээгүй байна.
- СТХ-иар иргэд, олон улсын байгууллагаас сонгуулийн ажиглалт хийх боломжийг хангасан байдаг. СЕХ нь сонгуулийн өдрийн үйл ажиллагааг голчлон ажиглах иргэдийн хоёр байгууллагыг бүртгэн, үнэмлэх олгоод байна. Ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ хүргүүлсэн хоёр байгууллага үнэмлэхээ аваагүй байна.

II. ОРШИЛ

2016 оны 1-р сарын 21-ний өдөр парламент (*Улсын Их Хурал*)-аас ээлжит сонгуулийг 6-р сарын 29-ний өдөр явуулахаар товлов. Монгол Улсын Гадаад хэргийн яамны урилгын дагуу, мөн 2016 оны 4-р сарын 5-наас 8-ны хооронд хийсэн Урьдчилсан судалгааны тайланд тусгагдсан зөвлөмж дээр үндэслэн ЕАБХАБ-ын Ардчилсан институт хүний эрхийн газар (ЕАБХАБ/АИХЭГ)-аас Сонгуулийг ажиглах хороо (САХ)-г 5-р сарын 20-ны өдөр байгуулав.¹ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны тэргүүнээр Элчин сайд Одри Гловер ажиллаж байгаа бөгөөд 15 хүний бүрэлдэхүүнтэй үндсэн баг нь Улаанбаатар хотод байрлаж, 5-р сарын 27-ны өдрөөс эхлэн 14 урт хугацааны ажиглагч (УХА) тодорхой газруудад байршин ажиглаж байна. Хорооны гишүүдийг ЕАБХАБ-ын гишүүн 21 улсаас бүрдүүлсэн. Гишүүн улс орнуудаас сонгуулийн өдрийн ажиллагааг ажиглуулахаар 300 богино хугацааны ажиглагч оролцуулах хүсэлтийг тавиад байна. УИХ-ын сонгуулийг аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуультай нэг өдөр явуулахаар товлосон. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь зөвхөн УИХ-ын сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт хийж, тайлан гаргана.

¹ ЕАБХАБ/АИХЭГ-аас Монгол Улсын талаар гаргасан өмнөх бүх тайланг үзнэ үү.

III. УЛС ТӨРИЙН ОРЧИН

2016 оны УИХ-ын сонгууль нь эдийн засаг зогсонги байдалд орж, олон нийт улс төрд итгэл алдарсан нөхцөлд явагдаж байна. Ерээд оны эхэн үеэс улс төрийн эрх мэдэл Ардчилсан нам (АН) болон Монгол ардын нам (МАН)-ын хооронд шилжиж ирсэн. 2012 оноос АН хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн аль алиныг хянаж, улс төрийн давуу эрх мэдэлтэй явж ирсэн. Мөн аймгуудын засаг дарга нарын ихэнх нь тус намд харьяалагддаг.² УИХ-д таван улс төрийн намын төлөөлөл байдаг. Тэдний дундаас АН, МАН болон Монгол ардын хувьсгалт нам (МАХН)-ууд нь орон нутагт өргөн бүтэц бүрэлдэхүүнтэй ажилладаг.

Үзэл баримтлал гэхээсээ илүү хувь хүний зан байдал улс төрийн үйл явцад чухал үүрэг гүйцэтгэж, түүнчлэн сонгуулийн мажоритар тогтолцоог баталсан нь жижиг намуудыг задрахад нөлөөлж байх шиг байна. МАН болон МАХН нэгдэн эвсэл байгуулах оролдлого амжилтгүй болсны дараа МАХН-ын зарим томоохон улс төрч, мөн тус намын орон нутгийн зарим байгууллага МАН-д дагаар оров. АН ч Иргэний Зориг-Ногоон Нам (ИЗНН)-ын гишүүдийг элсүүлэв.

Үндсэн хуулийн цэцийн дарга болон Авлигатай тэмцэх газрын даргыг 2016 оны 2, 4-р сард тус тус үүрэгт ажлаас нь чөлөөлөв. Шинэ дарга нарыг хараахан томилоогүй байгаа нь сонгуулийн үйл явцад чухал үүрэг бүхий энэ хоёр байгууллагыг сонгуулийн кампанит ажлын хугацаанд удирдлагагүй орхиж байгаа санаа зовоосон асуудлыг үүсгэж байна.

IV. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН СИСТЕМ

Монгол Улс нь олон улсын хүний эрхийн чухал конвенциудад нэгдэн орсон. 1992 оны Үндсэн хуулиар эдгээр арга хэрэгслийг дотоодын хууль тогтоомжуудад шууд хэрэглэх нөхцлийг бий болгож, эдгээрийг шударгаар сахин биелүүлэхийг шаарддаг. Үндсэн хууль нь өөрөө ардчилсан сонгуулийг бэхжүүлэх суурь эрх, эрх чөлөө, мөн түүнчлэн жендерийн тэгш байдал болон үл ялгаварлах зарчмыг баталгаажуулдаг.

Сонгуулийн хууль эрх зүйн орчин нь Үндсэн хууль, 2015 оны Сонгуулийн тухай хууль (СТХ), 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (СТБТХ), 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль (САСТХ) болон СЕХ-ны журам зэргээс үндсэндээ бүрдэж байна.³ Гэвч СЕХ нь шаардлагатай гэж үзсэн зохицуулалтыг батлах бүрэн эрх байхгүй, зохицуулалт шийдвэрүүдийн цар хүрээ нь СТБТХ болон СТХ-иар хязгаарлагдаж байна.

Талуудыг оролцуулсан хэлэлцүүлгийн үндсэн дээр сонгуулийн тухай хэд хэдэн хуулийг нэгтгэн, сонгуулийн тухай шинэ хуулийг 2015 оны 12-р сарын 25-нд баталсан.⁴ Уг хууль нь УИХ-ын сонгуульд холимог тогтолцоог ашиглахаар төлөвлөж, пропорциональ болон

² 21 аймгийн Засаг дарга нарын 16 нь, мөн Улаанбаатар хотын захирагч нь АН-ын харьяаллынх байна.

³ Холбогдох бусад хуулиудад Улс төрийн намын тухай хууль, Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн аудитын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон шүүх засаглал, хэвлэл мэдээллийг зохицуулах бусад хууль тогтоомжууд орно.

⁴ Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгууль, аймаг нийслэлийн болон сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг зохицуулсан дөрвөн хуулийг шинэ хуульд нэгтгэсэн.

мажоритар тогтолцооны зарим бүрэлдэхүүн хэсгийг нэгтгэжээ.⁵ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны гишүүдтэй уулзаж ярилцсан хүмүүс СТХ-нд хуулийн хийдэл, хоорондоо зөрчилдсөн, тодорхой бус заалтууд хэд хэд байгааг тэмдэглэсэн юм. Сонгуулийн эрх зүйн орчны талаар ЕАБХАБ/АИХЭГ-аас өгсөн өмнөх зөвлөмжүүдийг, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдыг сонгуульд оролцох нөхцөл боломжоор хангах зэргийг тусгасан боловч ихэнх зөвлөмжүүд нь тусгагдаагүй орхигдсон байна.

2016 оны 4-р сарын 22-ны өдөр Үндсэн хуулийн цэц хоёр өргөдөлд шуурхай шийдвэр гаргаж сонгуулийн хувь тэнцүүлэх буюу пропорциональ тогтолцоог иргэний “шууд” сонгох үндсэн хуулийн эрхийг зөрчиж байна хэмээн хүчингүй болгосон. УИХ нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх эрхтэй бөгөөд хуульд заасан хугацаа байхгүй хэдий ч дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, 5-р сарын 5-ны өдөр СТХ-нд нэмэлт, өөрчлөлт оруулан бүрэн мажоритар тогтолцоог тогтоон батлав.

Түүнчлэн УИХ олон мандат бүхий сонгуулийн тойргийн тогтолцоог нэг мандат бүхий тойргийн систем болгон өөрчилж, мажоритар тойргийн тоог 26-аас 76 болгон нэмэгдүүлж, сонгуулийн тойргийн тоог тогтоох эцсийн хугацааг сонгуулийн өдрөөс 150 хоногийн өмнө байсныг 45 болгож багасгав. Ингэснээр УИХ-ын гишүүд нь нэг мандаттай 76 тойрог дээр хамгийн олон санал авсан нь ялдаг системээр сонгогдох болж байна. Түүнчлэн сонгуулийн шинэ хуульд нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй байхаар заасан жендэрийн квот 20 хувь болж буурчээ. УИХ мөн парламентын сонгуульд гадаадад суугаа иргэдээс санал авахыг хүчингүй болгож, гадаадад амьдарч буй Монгол Улсын 150,000 орчим иргэдийн сонгуульд оролцох эрхийг хасав. Сонгууль болохоос зургаан сарын өмнө сонгуулийн хуулийг баталсан, мөн хоёрхон сарын өмнө сүүлийн суурь нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан зэрэг нь олон улсын сайн туршлагын үүднээс авч үзэхэд ноцтой асуудлыг үүсгэж байна.⁶

V. ТОЙРГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХУВААРИЛАЛТ

УИХ нь СЕХ-ноос ирүүлсэн саналыг үндэслэн сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг тогтоох бөгөөд хүн амын тоо, засаг захиргааны нэгжийн хуваарилалтыг харгалзан үзэж болдог. Харин эдгээр шалгуурыг бүрэн дагаж мөрдөөгүй байна.

5-р сарын 11-нд СЕХ-ноос сонгуулийн тойрог тус бүрт бүртгэгдсэн сонгогчдын талаар мэдэгдэхүйц ялгааг тусгасан сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг хэрхэн тогтоох тухай саналыг ирүүлэв. 5-р сарын 12-нд УИХ сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг дахин хуваарилж, 50 тойрог дээр тойрог тутамд 25,169 сонгогч оногдох улсын дундажаас 15-аас дээш хувиар хэлбийлгэж, 76 тойргийн нутаг дэвсгэрийг батлав.⁷ Түүнчлэн сонгогчид нь

⁵ Дөчин найман гишүүн олон мандаттай 26 тойрог дээр мажоритар системээр сонгогдож, нэг мандаттай үндэсний хэмжээний тойрог дээр таван хувийн босгоор 28 суудалд сонгогдоно.

⁶ 2002 оны Венецийн Комиссын дүрэм, II.2.b. Сонгуулийн асуудлаарх сайн туршлага. (Сайн туршлагын дүрэм)-ээр сонгуулийн хуулийн үндсэн элементүүдэд сонгууль болохоос өмнө сүүлийн 12 сарын дотор нэмэлт өөрчлөлт оруулах ёсгүй гэж зөвлөдөг.

⁷ Сайн туршлагын дүрмийн 2.2 (iv)-д тогтоосон хэм хэмжээнээс зөвшөөрөгдөх зөрүү нь 10-аас дээш хувь байх ёсгүй ба 15 хувиас огт хэтрэх ёсгүй гэж зөвлөдөг.

хоёр, гурван тойргийн дунд хуваагдсан 10 сум байгаагаас гадна хил залгаа оршдоггүй хэд хэдэн тойрог байна.⁸

VI. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

УИХ-ын сонгуулийг Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ), 22 Аймаг нийслэлийн сонгуулийн хороо (АНСХ), 339 Сум дүүргийн сонгуулийн хороо (СДСХ), 1,998 Сонгуулийн хэсгийн хороо зохион байгуулж байна. СЕХ-ны есөн гишүүнийг, түүний дотор нэг эмэгтэй гишүүнийг оролцуулан УИХ-аас зургаан жилийн хугацаатай 2012 онд томилжээ. Хорооны гишүүд нь төрийн албан хаагч байх ёстой. Хуулинд сонгон шалгаруулах өөр ямар нэг шалгуурын талаар заагаагүй бөгөөд СЕХ-ны гишүүдийг дур мэдэн шалтгаангүйгээр ажлаас чөлөөлөхөөс хамгаалсан байна.

4-р сарын 18-нд СЕХ нь орон нутгийн засаг захиргааны бэлтгэсэн төрийн албан хаагчдын жагсаалтаас АНСХ-дын бүрэлдэхүүн болох 196 ажилтныг сонгон томилсноос 43 хувь нь эмэгтэйчүүд байна. Үүнтэй адил журмыг АНСХ-д дээр 2000 гаруй СДСХ-дын ажилтан, СХХ-дын 14,000 орчим ажилтныг сонгохдоо баримталжээ. Сонгуулийн хороодын бүрэлдэхүүнийг томилох үйл явц 5-р сарын 30-наар дуусгавар болжээ. Сонгуулийн хороодын ажилтнуудыг сонгон шалгаруулах нэгдсэн зарчим ажиглагдсангүй. Орон нутгийн сонгуулийн байгууллагууд (СБ)-ад итгэх оролцогч талуудын итгэл харьцангуй ялгаатай байна. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд ирсэн мэдээллээр найман аймаг болон нийслэл хотын АНСХ болон СДСХ-дын бүрэлдэхүүнд улс төрийн ялгаварлал байна хэмээн үзэж байгаагаа илэрхийлжээ. Гэвч СБ-ын ажилтан, албан тушаалтнуудын томилгооны талаар гомдол маргаан бараг гараагүй байна.

СТХ-иар бүх шатанд ажиллаж буй СБ-уудыг гаргаж буй шийдвэрүүдээ ил тод, нээлттэй, олонхийн саналаар шийдвэрлэж байхыг шаарддаг. Гэхдээ ихэнх хурал нь олон нийтэд урьдчилан мэдээлэлгүйгээр *гэнэтийн байдлаар* явагдаж байгаагаас гадна хурлуудын талаарх мэдэгдлийг нийтлэх тогтсон систем байхгүй. СЕХ 5-р сараас хойш найман хурал хийгээд байна. СЕХ-ны цахим хуудас дээр тус байгууллагаас гаргаж буй шийдвэрүүдийн зарим нь тавигдаагүй бөгөөд хурлаар хэлэлцсэн асуудлууд, хурлын тэмдэглэлийн аль нь ч нийтлэгдээгүй. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид АНСХ-д болон СДСХ-д нь ил тод байдлын талаар баримталж буй СЕХ-ны арга барилыг ерөнхийдөө дууриаж байна гэж ажиглажээ.

Сонгуулийн шинэ тогтолцоог хожимдуулж баталсан нь сонгуульд бэлтгэх хугацааг илэрхий багасгасан. Гэсэн хэдий ч СЕХ нь одоогийн байдлаар хуульд заасан чухал хугацаандаа багтаан ажиллаж байна. Сонгуулийн байгууллагуудад ажиллах ажилтнуудад зориулсан сургалтууд, мөн ирэх сонгуульд ашиглах санал тоолох автоматжуулсан төхөөрөмжийн програмчлалын ажил явагдаж байна. Гэвч 2013 оны сонгуульд хүчингүй саналын хуудсыг буруу тоолсон явдал гарсан учраас санал тоолох үйл явц үнэн зөв хийгдэж байгаад оролцогч

⁸ Ховд аймагт хамгийн жижиг тойрог 11,304 сонгогчтой; Улаанбаатар хотын хамгийн том тойрог болох Чингэлтэй дүүргийн 63-р тойрог 41,836 сонгогчтой. Мөн Увс аймгийн 33-р тойрог нь зэргэлдээ биш гурван хэсэгт хуваагджээ. Улаанбаатар хотын гадна орших Багануур дүүрэг дөрвөн хэсэгт хуваагдаж, хэсэг тус бүр нь Баганууртай хил залгаа бус Сүхбаатар дүүргийн өөр өөр тойрогтой хуваарилагджээ.

талууд санаа зовж байгаа талаар ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид сонссон байна. СЕХ нь уг асуудлыг шийдвэрлэх үүднээс санал тоолох төхөөрөмжүүдийг дахин програмчилсан байна.

МАН-ын санаачилгаар 2015 оны 12-р сард ил тод байдал болон санал тоолох төхөөрөмжид итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор хэсгийн хороодын дор хаяж 50 хувь дээр гараар дахин тоолох тухай заалтыг СТХ-д оруулсан.⁹ СХХ-дын 50 хувь дээр санамсаргүй сонголтоор гараар дахин тоолох, мөн эдгээр хэсгийн хороодыг хэрхэн сонгох зэрэг журмыг СЕХ-ноос хараахан боловсруулаагүй байна. Энэ нь доод шатны сонгуулийн байгууллагуудын дунд санаа зовоосон асуудлыг үүсгээд байгаагаас гадна СЕХ-ноос мэдээлэл харилцаа дутмаг байгаа нь СТХ-ийг нэг ижил хэрэглэж чадахгүйд хүргэж магадгүй гэж тэд үзэж байна.

СЕХ нь иргэд, сонгогчдын боловсролд зориулсан хөтөлбөрийг боловсруулаад байгаа бөгөөд интернетээр үзэх боломжтой. Гэхдээ энэ нь уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэж харахад хараахан боломжгүй байгаа бөгөөд ялангуяа сонгуулийн шинэ системийн гол чухал элементүүдийг тусгаагүй байна. “Сонгогчдын боловсролын төв” төрийн бус байгууллага нь СЕХ-той хамтран нэгэн Facebook хуудас гаргаж, мэдээлэл авах утас ажиллуулсан байна. Үүнээс гадна зарим нэг байгууллагууд иргэдийн сонгуулийн боловсролд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Нэг иргэний нийгмийн байгууллага хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгогчийн боловсролын кампанит ажлыг эхлүүлж, мөн холбогдох төрийн байгууллагууд сонгогчийн нэрсийн бүртгэл болон сонгуулийн сурталчилгааны санхүүжилтын талаар сонгогчдод тайлбарлаж байна.

VII. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

Гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй бүх этгээдээс бусад 18 насанд хүрсэн болон эрх зүйн бүрэн чадамжтай бүх иргэн санал өгөх эрхтэй. Сонгогчийн бүртгэл нь иргэдийн шууд сонгох эрхийн үндсэн дээр явагддаг. Сонгогчдын нэрийн жагсаалт (СНЖ)-ыг Монгол Улсын Үндэсний иргэний бүртгэлийн мэдээллийн сангаас хувийн болон биометрийн мэдээллийг үндэслэн гаргадаг. СНЖ-ыг олон нийтэд зориулан цахим хэлбэрээр 3-р сарын 1-нээс эхлэн байрлуулсан ба 6-р сарын 9-нөөс эхлэн санал авах байруудад байршуулсан байх ёстой. Цөөн хэдэн газрыг эс тооцвол СХХ-д СНЖ-ыг хүлээн авсан гэж ЕАБХАБ/АИХЭГ-ийн ажиглагчид мэдээлжээ. Зарим хүн ам цөөтэй газруудад СХХ-ны ажилтнууд өөрсдийн санаачилгаар СНЖ дээрх алдааг сонгогчдод хэлж өгч, тэдгээр алдааг албан ёсоор засуулах тухай хүсэлт тавихыг санал болгож байна. СНЖ дээр ямарваа өөрчлөлт оруулахаар бол, тухайлбал сонгогчид өөр санал авах газар руу шилжих зэрэг хүсэлтийг 6-р сарын 15-ныг хүртэл хийж болно. Харин сонгогч нь санал авах байраа нэг аймаг, эсвэл Улаанбаатар хот дотор өөрчлөх боломжгүй. Нийт 1,912,901 сонгогч 2016 оны сонгуульд оролцохоор бүртгэгдсэн байна. Саналаа өгөхөөр бүртгүүлсэн сонгуулийн хэсгийн хороодоос өөр газар байршиж байгаа сонгуулийн байгууллагын ажилтнууд, цэргийн албан хаагчид зэрэг хүмүүс хууль эрх зүйн хязгаарлалт болон бодит нөхцөл байдлын улмаас саналаа өгч чадахгүйд хүрч болзошгүй байна.

⁹ Анх МАН санал тоолох электрон төхөөрөмжид итгэхгүй байна гэдгээ илэрхийлэн, 100 хувь гараар дахин тоолохыг санал болгосон.

VIII. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

25 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжаа алдаагүй нь нотлогдсон иргэн нэр дэвшигч байх эрхтэй. СТХ-иар сонгуульд нэр дэвшихийг хязгаарласан нэмэлт нөхцлүүдийг зааж өгсөн бөгөөд үйлдсэн гэмт хэргээс үл хамааран ял шийтгэлтэй, төлөгдөөгүй татварын болон зээлийн өртэй, түүнчлэн заавал хаах цэргийн албыг хаагаагүй иргэнийг хассан байна. Төрийн жинхэнэ албан хаагч нь нэр дэвшихээр бол сонгуулийн жилийн 1-р сарын 31-нээр албан үүргээсээ чөлөөлөгдсөн байх ёстой. Сонгууль болохоос 180 хоногийн өмнө Дээд шүүхэд бүртгүүлсэн намууд л нэр дэвшигчээ дэвшүүлэх боломжтой. Бие даан нэрээ дэвшигчид нь 801 дэмжигчийн гарын үсэг цуглуулсан байх ёстой.

УИХ-ын суудалд 69 бие даан нэр дэвшигчийг оролцуулан нийтдээ 498 нэр дэвшигч өрсөлдөж байна.¹⁰ Нэр дэвшигчдээ бүртгүүлсэн нийт 12 улс төрийн нам, 3 эвслээс зөвхөн АН болон МАН бүх тойрог дээр нэр дэвшүүлжээ. 10 ба түүнээс дээш өрсөлдөгчтэй хэд хэдэн тойрог дээр өрсөлдөөн ширүүн болохоор байна; мөн зөвхөн 2-хон өрсөлдөгчтэй 2 тойрог бий. Бүх улс төрийн намууд 20 хувийн жендэрийн квотыг мөрдөж байгаа ба АН, МАН-аас нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийн хувь хамгийн бага байна.¹¹ Ерөнхийдөө улс төрийн намаас нэр дэвшигчдийн 26 хувь, бие даагчдын 19 хувь нь эмэгтэйчүүд байна. Сонгуулийн тойргийн гуравны нэгээс илүү хувь дээр эмэгтэй нэр дэвшигч байхгүй.

Хоёр улс төрийн нам, 5 бие даан нэр дэвшигчийг оролцуулан нийт 13 нэр дэвшигчийг СЕХ хэд хэдэн үндэслэлээр бүртгэхээс татгалзсан байна. ИЗНН-ыг бүртгэлийн баримт бичиг нь зөрчилтэй гэдэг үндэслэлээр бүртгэхээс татгалзсан боловч Дээд шүүхэд хандан СЕХ-ны шийдвэрийг эсэргүүцэн, нэхэмжлэл гаргасан бөгөөд шүүх СЕХ-г нэр дэвшигчдийг бүртгэх журмыг буруу хэрэглэсэн гэж үзэж, тус намыг бүртгэх шийдвэрийг гаргажээ. МАХН-ын даргыг ял шийтгэлтэй гэж бүртгэхээс татгалзсан боловч мөн тэрээр СЕХ-ы шийдвэр болон цагдаагийн тодорхойлолтыг эсэргүүцэн шүүхэд гомдол гаргасан; 6-р сарын 13-ны байдлаар уг хэрэг хүлээгдсэн хэвээр байна.¹²

IX. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ОРЧИН БА ЗАРДАЛ

СТХ-иар сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгах зүйл зэргийг оролцуулан сонгуулийн сурталчилгаа хийх эрх зүйн орчныг нарийвчлан зааж өгчээ. Үндэсний аудитын газар (ҮАГ) нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийг эдийн засаг ба хөгжлийн тухай хууль, бодлогод нийцэж байгаа эсэхийг шалган урьдчилан батлах ёстой.¹³ Түүнээс гадна СТХ нь сонгуулийн

¹⁰ 6-р сарын 13-ны байдлаар, нэр дэвшигчийн бүртгэлийн эсрэг 6 хэрэг шүүх дээр хүлээгдэж байна.

¹¹ Хоёр намаас нэр дэвшигчдийн 21 хувь нь эмэгтэйчүүд байна. Бусад жижиг намууд нэлээд өндөр хувиар нэр дэвшүүлсэн байна. Жишээ нь, Иргэний Хөдөлгөөний Нам 12 эмэгтэйг нэр дэвшүүлсэн ба энэ нь намын нийт гишүүдийн 44 хувийг төлөөлж байгаа юм.

¹² Цагдаагийн лавлагаагаар ялтан нь өршөөгдсөн ч, түүний ял шийтгэлтэй тухай бүртгэл нь холбогдох өршөөлийн хуулийн дагуу хэвээр байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Эрүүгийн хуульд ял шийтгүүлсэн этгээдийн ялтайд тооцогдох хугацаа нь ялаа эдэлж дуусснаас хойш 1-10 жилийн хооронд байна гэж заажээ.

¹³ ҮАГ-аас ЕАБХАБ/АИХЭГ САХ-д улс төрийн намд, эвсэл болон бие даагч нараас хүргүүлсэн бүх мөрийн хөтөлбөрүүд нь хууль эрх зүйн шаардлагыг хангаагүй тул өөрчлөлт оруулахыг шаардсан гэж мэдээлжээ. Мөрийн хөтөлбөрт аудит хийх шалгуур болон үнэлгээний үр дүн олон нийтэд нээлттэй биш байна.

сурталчилгааг хэн, хэрхэн, хэзээ хийх эрхтэйг нарийвчилж зааж өгснөөс гадна хуулиар зөвшөөрснөөс бусад аливаа үйл ажиллагааг хориглосон хатуу зүйл заалттай. Үүний зэрэгцээ одоогоор сонгуульд албан тушаалаа хашиж буй хүмүүс сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө ямар нэг хориг хязгаарлалтгүйгээр өөрийн ололт амжилтыг олон нийтэд мэдээлэх боломжтой. Сонгуулийн сурталчилгаа нь 6-р сарын 11-ээс эхлэн 17 хоногийн туршид үргэлжилнэ. Сонгуулийн сурталчилгаа нь санал авах өдрөөс 24 цагийн өмнө зогсоно.

МАХН 3 өдрийн өлсгөлөн зарласныг, мөн тус намын хэд хэдэн удирдагчийг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг СЕХ-ноос гаргах вий гэсэн таамаг болгоомжлолыг эс тооцвол сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаа эхлэхээс өмнөх орчин ерөнхийдөө тайван байлаа.¹⁴ Сонгуулийн сурталчилгааг эрт эхлүүлсэн байх магадлалтай цөөн хэдэн тохиолдол гарсан. ЕАБХАБ/АИХЭГ-ын ажиглагчид одоогоор албан тушаалаа хашиж буй ч нэр дэвших магадлалтай хүмүүс олон нийтийн арга хэмжээнд оролцож байгаа нь сонгуулийн сурталчилгаа болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааны зааг ялгааг бүдгэрүүлж байгааг тэмдэглэсэн байна.¹⁵ Улаанбаатар хот болон Өмнөговь аймагт ажил, албан тушаал эрхэлж буй хүмүүсийн ололт амжилтыг сурталчилсан тараах материал сонгогчдод тарааж байсныг ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ноос тэмдэглэсэн байна. Үүнээс гадна сонгууль ойртсон үед Засгийн газар өндөр настны тэтгэврийн хэмжээг нэмсэн бөгөөд өмнө нь иргэдэд үнэ төлбөргүй хуваарилсан нүүрсний уурхайн хувьцааны 30 хувийг буцаан худалдаж авахаа зарласан юм.¹⁶ 6-р сарын 11-ний өдөр улс төрийн гол намууд нийслэл хот болон аймгуудад сонгуулийн сурталчилгааны албан ёсны нээлтээ хийв.

Сонгуулийн зардлын талаар сонгууль дууссаны дараа тайлагнахаас өөр шаардлагыг хуульд заагаагүй байна. УИХ-д суудалтай намууд жил бүр улсын төсвөөс санхүүжилт авдаг ба үүнийг сонгуулийн санхүүжилт гэж тооцдоггүй.¹⁷ Сонгуулийн сурталчилгааг хандиваар санхүүжүүлэх бөгөөд иргэний хувьд 3 хүртэл сая төгрөг, хуулийн этгээдийн хувьд 15 хүртэл сая төгрөг байхаар хязгаарлажээ.¹⁸ Бүх гүйлгээ нь тодорхой банкны дансаар дамжуулан хийгдэх ёстой. УАГ-аас тогтоож өгсний дагуу нэр дэвшигч тус бүрт сонгуулийн тойрог тус бүрээс хамаарч зарцуулах зардлын дээд хэмжээ 85 сая төгрөгөөс 225 сая төгрөг хүртэл янз бүр байна. Улс төрийн нам, эвсэл тус бүрт улсын хэмжээнд сонгуульдаа зарцуулах нэмэлт зардлын дээд хэмжээ нь 4.4 тэрбум төгрөг байна.¹⁹ Энэхүү нэмэлт дээд хэмжээг сонгуулийн тогтолцоог шинэчлэн тогтоосны дараа буюу 5-р сарын 18-ны өдөр баталсан нь санал авах өдрөөс 120-иос доошгүй хоногийн өмнө хэмжээг тогтоох гэсэн эцсийн хугацааг зөрчжээ.

¹⁴ 5-р сарын 28-нд өлсгөлөн зарлагчид нь СЕХ-ны дэргэд майхнаа барьж, дэмжигчдийн гарын үсгээ цуглуулжээ.

¹⁵ 6-р сарын 5-нд Хэнтий аймагт болсон замын төслийн нээлтийн үйл ажиллагааны үеэр оролцогчдыг засаг даргаа дэмжээрэй гэж уриалж байсан нь ажиглагджээ. Одоо тэрээр АН-аас нэр дэвшиж байгаа.

¹⁶ МУНН-аас нэр дэвшигч СЕХ-нд СТХ-ийн дагуу санал худалдаж авах гэсэн үндэслэлээр Ерөнхий Сайд болон УИХ-ын даргыг нэр дэвшүүлэхээс хасах тухай гомдлыг СЕХ-нд гаргасан. 6-р сарын 13-нд СЕХ уг хэргийг хууль эрх зүйн үндэслэл дутмаг хэмээн хянан хэлэлцэхээс татгалзжээ.

¹⁷ УТНТХ-иар сонгуулийн дараа УИХ-д суудалтай намууд хүчин төгөлдөр саналын хуудас бүрт 1,000 төгрөгтэй (ойролцоогоор 0.44 евро) тэнцэх мөнгийг авдаг ба намууд 4 сар тутамд нэг удаа нэг УИХ-ын гишүүн тутамд 10 сая төгрөг (ойролцоогоор 4400 евро) мөнгийг авдаг.

¹⁸ Ойролцоогоор 1,300 евро болон 6,600 евро тус тус байна.

¹⁹ 1,9 сая евро орчим

Х. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Хэвлэл мэдээллийн салбар нь ил тод ажиллаж байгаа хэдий ч улс төрийн харьяаллаар тодорхойлогдож байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөл ил тод биш. Хэвлэл мэдээлэл болон улс төрийн тоглогчид хооронд холбоотой байдаг. Зар сурталчилгааны зах зээл хязгаарлагдмал хэдий ч Монгол Улсад 400 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байна. Мэдээлэл авах гол эх үүсвэр нь телевиз хэвээр байгаа бөгөөд сонин хэвлэл зэрэг хэвлэмэл мэдээллийн тухайд энэ үзүүлэлт буурч байна. Харин интернэтийн хэрэглээ нэмэгдэж байгаа боловч хот ба хөдөө орон нутгийн цахим хэрэглээний зааг ялгаатай байна. 2006 оноос хойш Монголын үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ) нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний байгууллага болон өөрчлөгдсөн.

Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан байдаг бөгөөд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар хяналт тавих, түүнчлэн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хаан боогдуулсан хууль тогтоомжуудыг батлахыг хориглодог. Хүний нэр төрд халдан гутаах нь эрүүгийн гэмт хэрэг. 9-р сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжих, шинээр батлагдсан Эрүүгийн хууль нь хүний нэр төрд халдан гутаасан эрүүгийн хариуцлагыг хүчингүй болгосон. Гэвч сонгуулийн үеэр хүнийг гүтгэх, худал мэдээлэл тараах нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдох хэвээр байгаа бөгөөд нэг жил хүртэл хорих ялаар шийтгэнэ. Мөн түүнчлэн хүний нэр төр гутаасан хэрэгт их хэмжээний торгууль оногдуулахаар зааж өгсөн байна.

Хууль эрх зүйн орчин нь бүх нэр дэвшигчдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандах эрхийг олгосон байдаг боловч мэдээний хөтөлбөрийг нэг улс төрийн намд радио, телевиз тус бүр дээр нэг өдөрт таван минут байхаар хязгаарлаж өгчээ. СТХ-иар үнэ төлбөргүй болон төлбөртэй сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн цагийг олгосон байдаг бөгөөд далд зар сурталчилгаа явуулах, түүнчлэн сонгууль болохоос долоо хоногийн өмнө санал асуулга нийтлэхийг хориглодог. Мэтгэлцээнд дор хаяж дөрвөн улс төрийн нам, эсвэл бие даан нэр дэвшигчдийн төлөөллийг оруулсан байх ёстой.

2016 оны 4-р сарын 26-нд СЕХ болон Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) хамтран сонгуультай холбоотой нэвтрүүлгийн талаар журам баталсан. Олон нийтийн радио, телевизийг төлбөргүй нэвтрүүлгийн цагийг нэр дэвшигчдэд ижил тэгш нөхцлөөр олгохыг шаарддаг. Хуулийн хугацаа дууссанаас хойш хоёр хоногийн дараа буюу 6-р сарын 8-нд СЕХ төлбөргүй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарийг батлав. МҮОНТ-ээс 498 нэр дэвшигч тус бүрт 15 минутыг хуваарилах бөгөөд энэ нь сонгуулийн кампанит ажлын хугацаанд өдөрт долоо хүртэлх цаг болж байгаа юм. Хувийн радио, телевизээр нэвтрүүлэх төлбөртэй улс төрийн сурталчилгааны нэвтрүүлэг нь өдөрт 60 минутаас хэтэрч болохгүй. СЕХ-ны мэдээлснээр нийт 43 телевизийн суваг, 16 радио станц төлбөртэй нэвтрүүлгийг цацна.

СТХ-иар ХХЗХ болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ)-ыг хэвлэл мэдээллийн байгууллагууд хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавихыг үүрэг болгосон байна. ШӨХТГ нь хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл гомдлыг

шийдвэрлэх үүрэгтэй. Түүнчлэн СЕХ-ноос хэвлэл мэдээллийн байгууллагын ёс зүйн байдалд анхаарах хэвлэл мэдээллийн зөвлөлийг байгуулах ёстой. Эдгээр байгууллагын хууль эрх зүйн зохицуулалтууд нь хоорондоо давхацсан мэт харагдаж байна. Одоогийн байдлаар ШӨХТГ нь МАН-ын нэр дэвшигчээс ирүүлсэн 11 цахим хуудсыг СТХ-ийг санаатайгаар зөрчсөн гэх гомдлыг хянан үзээд, гүтгэн доромжилж, худал мэдээлэл тараасан гэж үзсэн. 6-р сарын 13-нд тус газраас ХХЗХ-нд эдгээр цахим хуудасны хандалтыг зургаан сарын хугацаагаар хаах саналыг хүргүүлсэн байна.²⁰ Мөн ХХЗХ нь өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хуулиар заасан эрхтэй.

5-р сарын 26-ны өдөр ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь өөрийн хэвлэл мэдээллийн мониторингийг хэвлэл мэдээллийн байгууллагуудаас түүвэрлэн авч, эхлүүлсэн бөгөөд сонгуультай холбоотой мэдээ, мэдээлэл дээр нь тоон болон чанарын дүн шинжилгээг хийж байна.²¹ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь мөн хэд хэдэн онлайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн сонгуультай холбоотой мэдээ мэдээллийг шинжилж байна.²² Сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслүүд гол төлөв АН болон МАН, түүнчлэн МАХН дээр төвлөрч байсан ба бусад нам, эвслийн талаар бага дурдаж байв. Мөн түүнчлэн Засгийн газрын ололт амжилтыг сурталчилсан телевизийн сурталчилгаа ихэнх телевизийн сувгаар маш ихээр цацагдаж байв. Тухайн хэвлэл мэдээллийн байгууллагаас редакцийн хяналтыг хэрэгжүүлэлгүй улс төрийн намуудын төлбөртэй бүхий л нэвтрүүлэг байнга цацагдаж байсан нь редакцийн хараат бус байдлын агуулга, бие даасан байдлыг сүүдэртүүлж байна.

XI. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

ЕАБХАБ/АИХЭГ-аас өмнө нь өгсөн зөвлөмжийн дагуу СТХ-иар өргөдөл гомдол гаргах, давж заалдах үйл явцыг тодорхой хэмжээнд тодруулж өгсөн байна. Аливаа хувь хүн болон хуулийн этгээд нь “сонгуулийн байгууллагын үйл явц, үйл ажиллагаа”-г хууль ёсны дагуу явагдаж байгаа эсэхэд сонгуулийн дээд шатны байгууллагад нь хандан гомдол гаргах боломжтой. СЕХ нь өргөдөл гомдлыг хорооны шийдвэрийн дагуу нээлттэй хуралдаанаар гурван өдрийн дотор шийдвэрлэх ёстой. Гэвч бодит байдал дээр СЕХ-ы дарга нь аль өргөдөл гомдолд өөрөө, эсвэл нарийн бичгийн дарга хариу өгч шийдвэрлэх, мөн ямар өргөдөл гомдолд хороогоороо шийдвэрлэхийг шийдэж байна. Түүнчлэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх үйл явц одоог хүртэл бараг бүхэлдээ олон нийтэд хүртээмжтэй биш байна.

СЕХ-ны шийдвэр болон үйлдэл, эс үйлдэхгүйг эсэргүүцсэн нэхэмжлэлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргах ба цаашлаад Дээд шүүхэд хандана. Энэ тогтолцоог 2016 оны 2-р сард СТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулахад баталсан. Гомдол, маргаан хянан шийдвэрлэх үйл явцыг яаралтай шинэчлэх хэрэгцээ тодорхой бус байгаа ба ЕАБХАБ/АИХЭГ САХ-тай уулзаж ярилцсан хүмүүсийн санааг зовоосон асуудал болж байна. Үндсэн хуулийн цэц нь СЕХ-оос гарч буй шийдвэрүүдийг Үндсэн хуультай нийцэж

²⁰ Цахим хуудаснууд нь: Grandnews.mn, Zuwluguu.com, Paparatsi.mn, Kaka.mn, Shar.mn, Janjin.net, Goomaral.com, Mnews.mn, Agshin.mn, Choibalsan.mn болон Medee.nuudel.mn

²¹ Сонгон авсан хэвлэл мэдээллийн байгууллагуудад таван телевизийн суваг (MNB, Eagle TV, Mongol HD TV, TV5, TV9)-ийг өдөр бүр 18:00 – 24:00 цагийн хооронд, нэг радио суваг (MNB Радио 1), өглөөний мэдээний болон өдөр тутмын дөрвөн сонин (Өдрийн сонин, Үнэн, Өнөөдөр, Зууны мэдээ) орж байна.

²² Ikon.mn, news.mn, polit.mn, shuud.mn болон sonin.mn

байгаа эсэхэд голлож анхаардаг. Сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх эцсийн хугацааг ЕАБХАБ/АИХЭГ-аас өгсөн өмнөх зөвлөмжүүдийн дагуу тодорхой хэмжээгээр бууруулсан байна.

СТХ-иар захиргааны зөрчлүүдэд, тухайлбал сонгуулийн сурталчилгаатай холбоотой зөрчлүүдэд төрийн албанаас халах, торгууль оногдуулах зэрэг шийтгэлүүдийг тогтоож өгсөн байдаг. Түүнчлэн уг хуулиар хэрэв нэр дэвшигч нь 23:00 цагаас хойш чанга яригч ашигласан зөрчилд нэр дэвшигчийг хасах нөхцлийг оруулсан байна. Эрүүгийн хуульд цагдаа болон шүүхийн бүрэн эрхэд хамаарах сонгуулийн холбогдолтой хэд хэдэн зөрчлийн талаар заасан байна.

ХИ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулах, тэдний хэрэгцээ ба шаардлагыг багтаасан хууль эрх зүйн арга хэрэгслүүдийг хангаж өгсөн байдаг. 2009 оноос хойш Монгол Улс нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон. СТХ-иар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн санал өгөх эрхийг хөнгөвчлөх хэд хэдэн зайлшгүй арга хэмжээнүүдийг заан өгч, хуучин СТХ-ийг сайжруулжээ. СЕХ нь санал авах байруудад нэвтрэх боломжтой болгож, Брайл хуудсаар хангахын зэрэгцээ бүх санал авах байруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дор хаяж нэг бүхээгтэй байлгах боломжийг хангах ёстой. Хүний эрхийн үндэсний комисс нь эдгээр шаардлагын биелэлтийг харж ажиглана.

2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн байгууллагуудад сонгуулийн сурталчилгаагаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох, мөн тэднийг нэр дэвших болон сонгогдоход дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг заажээ. Хамгийн багадаа хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэн сонгуульд өрсөлдөж байна.

ХИИ. ИРГЭД БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАЛТ

СТХ-иар иргэд, олон улсын байгууллагаас сонгуулийн ажиглалт хийх боломжийг хангасан байдаг. Ажиглагч байгууллагыг СЕХ-оос итгэмжлэн үнэмлэх олгодог; СХХ нь ажиглагч хийх хувь хүмүүст үнэмлэх мөн олгоно. Сонгуулийг ажиглах хүсэлтээ санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө СЕХ-нд хүргүүлсэн байх ёстой. СЕХ нь сонгуулийн өдрийн үйл ажиллагааг голчлон ажиглах иргэний нийгмийн хоёр байгууллагыг бүртгэн, үнэмлэх олгоод байна. “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ” 200 ажиглагч, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв” 10 ажиглагч ажиллуулахаар тус тус төлөвлөөд байна.

Ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх хүсэлтээ хүргүүлсэн өөр хоёр байгууллага үнэмлэх аваагүй. СЕХ-ноос мэдээлснээр “Иргэний шударга шүүх” ТББ-ын тэргүүн нь нэр дэвшигч бөгөөд “Сонгогдох эрх, шударга ёс” ТББ-ын гишүүд нь МАН-ын харьяа гэж СЕХ үзэж байгаатай холбогдуулан үнэмлэх олгох шаардлагуудыг хангаагүй гэжээ. Гэвч СЕХ нь энэ асуудлаар албан ёсны ямар шийдвэр гаргаснаа ЕАБХАБ/АИХЭГ САХ-нд мэдэгдээгүй байна.

XIV. ЕАБХАБ/АИХЭГ-НЫ САХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь 2016 оны 5-р сарын 20-ны өдөр хэвлэлийн бага хурал хийн, Монгол Улсад үйл ажиллагаагаа эхлүүлэв. САХ-г Гадаад хэргийн яамнаас хүлээн авч, төр, засгийн газрын бусад эрх бүхий байгууллагуудтай, онцгойлон СЕХ, мөн түүнчлэн улс төрийн намууд, хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийн төлөөллүүдтэй уулзав. ЕАБХАБ-ын гишүүн болон хамтран ажилладаг түнш орнуудын дипломат төлөөлөгчидтэй хийсэн анхны уулзалт 6-р сарын 7-нд болж өнгөрөв. Бүх УХА-дын баг холбогдох зааварчилгаа авч, сургалтад хамрагдаж, ажиглагчийн үнэмлэхээ гардан аваад, 5-р сарын 27-ны өдөр ажлаа эхлүүлсэн бөгөөд хөдөө, орон нутгийн СБ-ууд, төрийн байгууллагууд, улс төрийн намууд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцаа холбоо тогтоогоод байна. ЕАБХАБ/АИХЭГ нь сонгуулийн өдрийг ажиглуулахаар өөрсдийн сонгуулийн ажиглагчдын төлөөллийг ирүүлэх Европын Парламенттай хамтран ажиллах болно.

*Энэхүү тайлангийн Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны хувь болно.
Монгол хэл дээрх албан бус орчуулгыг авах боломжтой.*